

ЭРХЭМ ЗОРИЛГО

Сургалтанд сонгогдож хамрагдаж буй оролцогчид манай төвөөс Европ, Ази,

Барууны орнууд болон АНУ-д суралцах зөвлөх үйлчилгээг авах боломжтой. Гадаадын их дээд сургуулиудад суралцах сонирхолтой сурагчдын зорилго төлөвлөгөөг тодорхойлохын тулд бидэнд сургуулийн багш болон менежерүүдийн туслалцаа хэрэгтэй.

- Сургалт хөгжлийн 4 үйл явц
- Сурагчдаас асуулга авч тулгарч буй асуудал, хүсэл эрмэлзлийг тодорхойлох
- Сурагчдад тодорхойлогдсон хэрэгцээ шаардлага болон асуудал дээр зөвлөгөө өгч, цаашдын зорилгодоо хүрэх арга замыг тодорхойлох
- Амжилтанд хүрэхэд нь тус нэмэр болох сургалт, семинар санал болгох
- Сурагчдад сайн сургуульд суралцах боломжийг нээж өгөх, гэр бүлийн эрүүл орчинг бүрдүүлэх, хаалттай байсан боломжуудыг нээж өгөх болон багш нарт сурагчдынхаа хөгжлийн үйл явцад илүү хяналт тавихад туслах.



БАРИМТЛАХ ЗАРЧИМ

#Нэгт. Хаана сурахаа шийдэх

- Хувь хүн нь аль оронд сурах сонголтоо хамгийн эхэнд шийднэ.
 - Өөрийн чадамж, чадвараа мэддэг байх.
- Манай байгууллага нь таны боловсролын чадамж, чадварт тохирох боломжтой хамгийн сайн сургуулиудыг сонгож өгнө.
- Санал болгосон сургуулиудаас таны сонирхол татсан сургуулийн амьдрах орчин нөхцөлийг судалж нэмэлт зөвлөгөө өгнө.

#Хоёрт. Нарийн судалгаа

- Таны сонгосон сургуулийн талаарх элсэлтийн шаардлагууд, боломжит тэтгэлэгүүд, хичээлийн програм болон хөтөлбөрүүдийг бид танд нарийн судалж танилцуулна.
- Мөн тухайн сургуулийг төгссөнөөр ирээдүйд сайн цалинтай, дуртай байгууллагууддаа орох боломжтой эсэхийг нэмэлтээр судалж өгнө.

#Гуравт. Шалгалтад системтэй бэлдэх

- Манай байгууллага нарийн судалгаагаа хийсний дараагаар таны сонгосон сургуулиудын шалгуурт тохируулан төвшин тогтоох шалгалт танаас авна.
- Сургуульд тань тэнцүүлэхийн тулд таны төвшнөөс шалтгаалаад бид танд хэдэн сар тухайн шалгалтдаа бэлдэх хэрэгтэй талаар зөвлөж санал болгоно.
- Зөвлөмжийн дагуу та манай гадаад багштай шат дараалалтайгаар хамтран ажиллаж, суралцана.

#Дөрөвт. Цагтаа багтааж шаардлагуудыг хангах

- Таны материалуудыг явуулсны дараагаар тухайн сургуулиас хариу ирэх үед, тавьсан шаардлагуудын дагуу шалгалтын дүн, сургуулийн голч дүн болон бусад бичиг баримтуудыг цаг тухай бүрт нь явуулна.
- Ингэснээр та тухайн сургуулийн тэтгэлэг болон төлбөрийн хөнгөлөлтийн системийн санд хамрагдах боломжтой болно.

#Тавд. Санхүүгийн тооцоо гаргах

- Тухайн сургууль таныг хүлээн зөвшөөрснийг бидэнд мэдэгдүүлсний дараа сургуулийн үндсэн төлбөр, оюутны байр болон амьдралын өртгийг бид нар тооцоолно.
- Үүний дараагаар тухайн сургуулийнхаа тэтгэлгийн сан болон төлбөрийн хөнгөлөлтийн системийг судалж өөрийн шаардлага хангасан чадамжаар хир хэмжээний төлбөрийн хөнгөлөлт болон тэтгэлэг авах хүсэлт, анкетуудыг илгээнэ.
- Таны санхүүгийн чадамжтай байдлыг тань харгалзан төлбөр төлөх төлөвлөгөөг хамтдаа гаргана.

ХӨТӨЛБӨР

1. Зөвлөх үйлчилгээ

Төлөвлөгөө гаргах. Өөрийн зорилгоо тодорхойлох. Давуу болон сул талаа ялгах. Үүн дээр үндэслэн бид сурагчидын яг юу хийх хэрэгтэйг тодорхой болгоно.

2. Сургалтын төлөвлөгөө

Сурагчдын хүсэл зорилгыг тодорхой болгосны дараа бид түүндээ хүрэх нарийвчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулна.

3. Багш нарт зориулагдсан сургалт

Хэлний мэдлэгээс шалтгаалан маш олон энгийн зүйлс орхигддог. Иймд бид багш нарт SAT Math заах мөн референс бичихэд нь мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх болно

4. Сургууль сонгох

Дэлхий даяар хэдэн арван мянган хөтөлбөр, сургуулиуд байдаг. Тиймээс бид танд тохирох хамгийн зөв сургуулийг сонгоход тусална.

5. Сургалт болон шаардлагатай бэлтгэл ажлууд

Бид сурагчидын өөрсдийнх нь гаргасан төлөвлөгөөнд тохирох англи хэлний сургалтыг олгож, шалгалтад бэлдэхэд тусална

6. Сургуульд элсэх явц

Бид сурагчидын сургуульд элсэх эссэ бичих, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хамгийн гол нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн төлөвлөлт зэргээр тусална

АЛХМУУД

1

Бид сурагчдад өөрсдийн үйл ажиллагаагаа самбар, зарлал зэргээр танилцуулах бөгөөд бид сургууль тус бүрээс ирээдүйд нь хэрэг болохуйц үнэ төлбөргүй хичээл, зөвлөгөө өгөх, сургалтанд хамрагдахад шаардлага хангах сурагчдыг сонгох юм. Багш нараас нь санал болгосон онц дүнтэй болон дунд, дундаас дээш түвшиний англи хэлтэй сурагчдыг хамруулна.

2

Бид тэнцсэн сурагчидтай богино хэмжээний ярилцлага хийн, тэдний онцгой чадвар болон ирээдүйн хүсэл зорилгын талаар ярилцан, түүндээ хэрхэн төлөвлөгөөт арга замаар хүрэх болон тулгарч болох асуудлууд болон хэрхэн даван туулах тал дээр туслалцаа үзүүлэхэд бидний гол зорилго оршино. (Мөн тухайн үйл ажиллагаа нь багш-сурагч-эцэг эхийн зөвшөөрөлтэй, туслалцаатайгаар явагдах тул тэдний холбоог сайжруулах болно.)

3

Сурагчдаас асуулга авч тулгарч буй асуудал, хүсэл эрмэлзлийг тодорхойлох

- Сурагчдад тодорхойлогдсон хэрэгцээ шаардлага болон асуудал дээр зөвлөгөө өгч, амьдралын зорилгодоо хүрэх арга замыг тодорхойлох
- Амжилтанд хүрэхэд нь тус нэмэр болох сургалт, семинар санал болгох
- Сурагчдад сайн сургуульд суралцах боломжийг нээж өгөх

Манай төвийн сургалт хөгжлийн арга хэмжээ дууссан ч сурагчид нь холбоотой байж зөвлөгөө авахад үргэлж нээлттэй байдаг.

БИДНИЙ ТУХАЙ

ADIS MONGOLIA

*Өсөлт ба хөгжлийн тогтвортой
замыг бүтээх*

Бид нийгэм, эдийн засгийн дэвшилтэт төслүүдийг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд гадаад худалдаа, боловсрол, хөтөлбөр хэрэгжүүлэх салбаруудад хамгийн тогтвортой-үр дүнтэй шийдлүүдийг санал болгодог билээ.

Бид Монгол улсын Улаанбаатар хот болон АНУ-н Нийслэлд төвлөрч үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тогтвортой хөгжлийн замыг бүтээх, зөвлөгөө өгөх мөн баттай мэдээллийн эх сурвалжаар дамжуулан Монгол иргэдийн амьдрах нөхцөл байдлыг сайжруулахыг зорьдог.



76110765
88111916



ADIS MONGOLIA

Дотоод-Олон Улсын Үйлчилгээний Агентлаг



2021 ОНЫ

GATE ХӨТӨЛБӨР